

**“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ ЁС ЗҮЙ, САХИЛГА
ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, мөрдүүлнэ” гэж заасны дагуу Улсын Их Хурлын даргын 2023 оны 209 дүгээр захирамжаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөр ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Б.Баярсайхан, Б.Бейсен, Н.Энхболд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан.

Уг ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Монгол Улсын Их Сургууль, Удирдлагын академи, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэн зэрэг байгууллагын төлөөлөл мэргэжил, арга зүйгээр хангасан.

Тухайн хөтөлбөрийн төслийг Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн дэмжлэгтэйгээр Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас, d.parliament.mn цахим талбарт байршуулж, олон нийтээс санал авч, Төрийн албаны зөвлөлийн цахим хэлэлцүүлэгт 2800 гаруй төрийн албан хаагчийг оролцуулан төслийг хэлэлцүүлсэн бөгөөд яам, агентлагийн удирдах албан тушаалтнууд, иргэний нийгэм, судалгааны байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд зэрэг байгууллагын удирдлагыг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг 7 удаа зохион байгуулж, нийт 45 төрийн болон төрийн бус байгууллагаас 520 гаруй санал ирүүлснийг нэгтгэн тусгаж хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан төрийн албаны цахим бүртгэлд хэдэн төрлийн үйлчилгээ бүртгэгдсэн талаар, төрийн албаны шуурхай байдлыг хангахад цаашид хэрэгжүүлэх бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд төрийн албан хаагчдыг цахим бүртгэлд хамруулж, дараагийн асуудлуудыг шийдвэрлэдэг байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хөтөлбөрийн төсөлд тусгасан төрийн албан хаагч гэдэгт захиргааны болон тусгай албан хаагчаас гадна улс төрийн албан хаагчийг хамруулсан эсэх талаар асуулт асууж, санал гаргасныг төсөлд тусган

тогтоолын төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Б.БАТТӨМӨР